

# ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ӨМА-2023/20/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:Usukhbayarts@audit.gov.mn">Usukhbayarts@audit.gov.mn</a>
Өмнөговь аймаг	Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:Khongorzult@audit.gov.mn">Khongorzult@audit.gov.mn</a>
Даланзадгад сум	Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:Bolormaa.ja@audit.gov.mn">Bolormaa.ja@audit.gov.mn</a>
2023 он	Аудитор: Н.Хулан Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:Khulann@audit.gov.mn">Khulann@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	10
Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 7,982.4 сая төгрөг болж, өмнөх оноос 500.7 сая төгрөгөөр өссөн байна.....	10
3.5.2 Авлага .....	10
3.5.3 Урьдчилгаа.....	10
3.5.4 Бараа материал.....	10
3.5.5 Үндсэн хөрөнгө.....	11
3.5.6 Өр төлбөр.....	11
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.5.1 Завсрын аудитын талаар .....	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	14
5.1 Төлбөрийн акт .....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

#### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААН	Аж ахуй нэгж
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.24 № 272

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА  
Б.ОРГИЛБОЛД ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 06/293 дугаар тушаалаар нийгмийн даатгалын байгууллагаас олгож буй шимтгэл төлөлтийн лавлагааг үнэ төлбөргүй байхаар шийдвэрлэсэн байна.

### Аудитын гол асуудал

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 51.0 сая төгрөг хүлээн авч хөрөнгө бэлтгэсэн нь үндсэн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.

### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016020360

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		48,085,201.9	32,715,712.8
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	7,481,727.0	7,982,449.2
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	40,587,377.8	24,725,055.8
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	16,097.1	8,207.8
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		1,565,704.9	1,580,224.7
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	1,565,704.9	1,580,224.7
39200	<b>Биет хөрөнгө</b>		1,451,004.9	1,465,524.7
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	13	114,700.0	114,700.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		49,650,906.8	34,295,937.5
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		282,164.4	1,225,373.4
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	282,164.4	1,225,373.4
41300	<b>Өглөг</b>	17а, 17б	9,087.2	3,604.1
41400	<b>Урьдчилж орсон орлого</b>	18а, 18б	273,077.2	1,221,769.3
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		49,368,742.4	33,070,564.1
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		49,368,742.4	33,070,564.1
51100	<b>Засгийн газрын оруулсан капитал</b>		453,350.0	453,350.0
511001	<b>Улсын төсвийн оруулсан хөрөнгө</b>		453,350.0	453,350.0
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		48,912,459.2	32,614,281.0
51300	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>		2,933.1	2,933.1
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		49,650,906.8	34,295,937.5

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		84,226,843.79	121,003,033.00
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		80,020,126.12	109,850,874.00
112	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>		80,020,126.12	109,850,874.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1а, 1б	138,940.63	54,372.50
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		138,940.63	54,372.50
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		4,067,777.04	11,097,786.50

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	75,002,019.96	137,282,149.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ		75,002,019.96	137,282,149.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		669,485.70	685,321.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		445,331.70	458,940.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		58,664.00	58,538.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		22,713.00	22,984.40
2104	Хангамж, бараа материалын зардал		19,646.80	20,517.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,935.00	8,378.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		37,151.90	11,842.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		77,043.30	104,121.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		74,332,534.26	136,596,827.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		9,224,823.80	-16,279,116.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		9,224,823.80	-16,279,116.20

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	40,122,589.8	40,122,589.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	21,328.8	21,328.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	40,143,918.6	40,143,918.6
9	Тайлант үеийн үр дүн	9,224,823.8	9,224,823.8
10	2021 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	49,368,742.4	49,368,742.4
11	2022 оны 1-р сарын 1- нээрх үлдэгдэл	49,368,742.4	49,368,742.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-19,062.0	-19,062.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	49,349,680.3	49,349,680.3
19	Тайлант үеийн үр дүн	-16,279,116.2	-16,279,116.2
20	2022 оны 12-р сарын 31- наарх үлдэгдэл	33,070,564.1	33,070,564.1

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		76,180,835.7	137,885,895.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО		71,361,458.7	109,959,320.2
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		71,361,458.7	109,959,320.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		247,214.0	53,385.7
120	Нийтлэг татварын бус орлого		247,214.0	53,385.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,572,163.0	27,873,189.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		75,201,111.8	137,334,173.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		75,201,111.8	137,334,173.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		598,916.2	574,216.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		445,331.7	458,940.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		58,664.0	58,538.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		22,713.0	22,984.4
2104	Хангамж, бараа материалын зардал		24,271.6	14,454.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		10,225.0	8,885.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		36,022.0	8,828.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,689.0	1,585.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		74,602,195.6	136,759,956.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		979,723.9	551,722.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		0.0	51,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	51,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр		0.0	51,000.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		0.0	-51,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		979,723.9	500,722.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,502,003.1	7,481,727.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		7,481,727.0	7,982,449.2

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>63,378,222.3</b>	<b>63,173,075.7</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>63,378,222.3</b>	<b>63,173,075.7</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>644,539.0</b>	<b>566,816.7</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	513,092.2	458,940.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,136.5	58,538.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,095.2	22,984.4
Хангамж, бараа материалын зардал	17,393.1	14,454.5
Эд хогшил, урсгал засварын зардал	2,355.4	1,485.7
Томилот, зочны зардал	3,325.0	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,241.6	8,828.1
Бараа үйлчилгээний бусад зардал	1,900.0	1,585.6
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>62,733,683.3</b>	<b>62,606,258.9</b>
Бусад урсгал шилжүүлэг	62,733,683.3	62,606,258.9
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>63,378,222.3</b>	<b>118,983,767.7</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>26,348,467.1</b>	<b>26,348,467.1</b>
<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>37,029,755.2</b>	<b>92,599,325.3</b>
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0.0</b>	<b>35,975.3</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	7,481,727.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	7,982,449.2

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>69,743.8</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>18,743.8</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>7,400.0</b>
Эд хогшил, урсгал засварын зардал	7,400.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,343.8</b>
Бусад урсгал шилжүүлэг	11,343.8
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>51,000.0</b>
Дотоод эх үүсвэрээр	51,000.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>69,743.8</b>
Нэмэлт санхүүжилтийн орлого	69,743.8

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын үйл ажиллагаа явуулдаг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Өмнөговь аймгийн Нийгмийн Даатгалын хэлтэс нь эрхэм зорилгоо “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэж тодорхойлсон байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,354.9 сая төгрөгөөр буюу 10.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,481.73	7,982.45	- 15,369.49
Авлага	40,587.38	24,725.06	- 15,862.32
Бараа материал	16.10	8.21	- 7.89

Үндсэн хөрөнгө	1,565.70	1,580.22	14.52
<b>Нийт хөрөнгө</b>	<b>49,650.91</b>	<b>34,295.94</b>	<b>-5,354.97</b>
Өр төлбөр	282.16	1,225.37	943.21
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	49,368.74	33,070.56	-
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>49,650.91</b>	<b>34,295.94</b>	<b>- 15,354.97</b>

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлагын үлдэгдэл өмнөх оноос 15,369.5 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 7,982.4 сая төгрөг болж, өмнөх оноос 500.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/сая төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>7,481.72</b>	<b>7,982.44</b>	<b>500.72</b>
<b>Төгрөг</b>	<b>7,481.72</b>	<b>7,982.44</b>	<b>500.72</b>
Төрийн сангийн харилцах	2.25	0.03	-2.22
Арилжааны банк дахь харилцах	7,479.46	7,982.42	502.96
<b>Дүн</b>	<b>7,481.72</b>	<b>7,982.44</b>	<b>500.72</b>

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 24,725.1 сая төгрөг болж, өмнөх оноос 15,862.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/сая төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага	7,776.00	8,740.14	964.14
Татаас, санхүүжилтийн авлага	32,793.30	15,956.76	-16,836.54
Байгууллагаас авах авлага	18.07	28.15	10.08
<b>Дүн</b>	<b>40,587.37</b>	<b>24,725.05</b>	<b>-15,862.32</b>

Авлага буурсан нь ковид-19 цар тахлын холбоотойгоор үүсгэсэн ААН-ийн нийгмийн даатгалын шимтгэл чөлөөлөлтийн авлага бууруулсантай холбоотой байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 8.2 сая төгрөг болж, өмнөх оноос 7.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/сая төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Хангамжийн материал</b>	<b>16.09</b>	<b>8.20</b>	<b>-7.89</b>
Бичиг хэргийн материал	1.03	0.93	-0.1
Аж ахуйн материал	8.36	2.86	-5.5

Сэлбэг хэрэгсэл	3.28	3.79	0.51
Түлш, шатах тослох материал	0.46	0.00	-0.46
Бусад хангамжийн материал	2.94	0.60	-2.34
<b>Дүн</b>	<b>16.09</b>	<b>8.20</b>	<b>-7.89</b>

Бараа материал дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд зарим нэр төрлийн үнэт цаас маягтыг ашиглахаа больж акталсан, аж ахуйн материал зарцуулснаас шалтгаалжээ.

### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,580.22 сая төгрөг болж, өмнөх оноос 14.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>1,451.00</b>	<b>1,465.52</b>	<b>14.52</b>
Барилга, байгууламж, орон сууц	1,506.34	1,506.34	-
Авто-тээврийн хэрэгсэл	20.97	20.97	-
Машин тоног төхөөрөмж(компьютер)	114.07	208.04	93.97
Тавилга, аж ахуйн эд хогшил	88,94	98.73	9.79
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>114.70</b>	<b>114.70</b>	<b>-</b>
Программ хангамж	3.10	-	-3.10
Бусад биет бус хөрөнгө	114.70	114.70	-
<b>Дүн</b>	<b>1,565.70</b>	<b>1,580.22</b>	<b>14.52</b>

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар үндсэн хөрөнгө худалдан авсан, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/184, А/193 тушаалаар машин тоног төхөөрөмж хуваарилсан хөрөнгө орлогод авснаас шалтгаалжээ.

### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,225.4 сая төгрөг болж, өмнөх оноос 943.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	9.09	3.60	-5.49
Урьдчилж орсон орлого	273.07	1,221.76	948.69
<b>Дүн</b>	<b>282.16</b>	<b>1,225.37</b>	<b>943.21</b>

Өр төлбөрийн дансны үлдэгдэл өссөн нь томоохон тээврийн компани, уул уурхайн компаниуд нийгмийн даатгалын шимтгэлийг их хэмжээгээр урьдчилж төлснөөс шалтгаалжээ.

### 3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 49,368.7 сая төгрөг болж, өмнөх оноос 15,072.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	453.35	453.35	-

<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>48,912.45</b>	<b>32,614.28</b>	<b>16,298.17</b>
Өмнөх үеийн үр дүн	39,687.63	48,893.97	9,206.34
Тайлант үеийн үр дүн	9,224.82	-16,279.12	-7,054.30
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2.93	2.93	-
<b>Дүн</b>	<b>49,368.74</b>	<b>34,295.94</b>	<b>-15,072.80</b>

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 51,998.6 сая, нийт зарлагыг 48,785.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагч нийт орлогыг 65,751.14 сая төгрөг, төсвийн төслийн саналаас зардлыг 14,301.1 сая төгрөгөөр өсгөж, 63,086.9 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсөвт тодотгол Засгийн газрын “Тэтгэврийн хэмжээ нэмэгдүүлэх тухай” 2022 оны 63 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар, Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба хаасны тэтгэврийн доод хэмжээг 0.5 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 0.4 сая төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор хийгдсэн байна.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангийн төсвөөс 674.9 сая, орон нутгийн хөрөнгө буюу ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 69.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлого болох 0.2 сая төгрөгийг НДЕГ газарт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 63,173.1 сая төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг 75.7 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Энэ хэмнэлтийн дийлэнх хувийг буюу 70%-ийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын хэмнэлт эзэлж байна.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа, аудитор Н.Хулан нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 51 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 501.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 218.3 сая төгрөгийн 7 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 24.6 сая төгрөгийн 7 хууль хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгч ажилласан. Асуудлын бүртгэлээр өгсөн зөвлөмжийн биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үзэхэд шатахууны норм мөрдөж ажиллах 1 зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 9. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	7	24.6	6	24.4	98.8
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>24.6</b>	<b>6</b>	<b>24.4</b>	<b>98.8</b>

Шатахуун зарцуулахдаа Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Жишиг норм батлах тухай" журамд заасан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулж зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.1 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

#### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд сахилгын шийтгэлтэй ажилтанд 704,225.0 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1 "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.", 2.7 "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалтай тус тус нийцэхгүй байна.

5.1.2 Шатахууны тооцооллыг тулган баталгаажуулахад 342,755.0 төгрөгийн шатахууныг норм хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Жишиг норм батлах тухай" журамд заасан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ын холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	2	1.1	2	1.1								
Дүн	2	1.1	2	1.1								

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	1	218.3			1	218.3		
Дүн	1	218.3			1	218.3		